



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/88/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 111

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,090.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5,799.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,000 мянган төгрөгийн гадна тоглоомуудыг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526050122

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 643,508.3 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 18.9 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 58 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96.0 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	200,578,410.34	106,877,837.96
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	165,663,541.99	53,723,135.32
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа	165,663,541.99	53,723,135.32
3121	Төгрөг	165,663,541.99	53,723,135.32
31211	Төрийн сангийн харилцах	165,663,541.99	53,723,135.32
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,914,868.35	53,154,702.64
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	34,914,868.35	53,154,702.64
35410	Бичиг хэргийн материал	3,793,000.00	5,241,500.00
35420	Аж ахуйн материал	12,361,630.00	21,350,485.52
3545	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	5,649,828.35	5,370,355.44
35470	Бусад хангамжийн материал	13,110,410.00	21,192,361.68
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,399,562,205.07	1,368,857,518.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,399,562,205.07	1,368,857,518.54
392	Биет хөрөнгийн дүн	1,282,596,205.07	1,252,155,518.54
39201	Барилга байгууламж	1,363,999,924.00	1,360,016,761.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(162,704,099.65)	(195,249,777.25)
39205	Машин тоног төхөөрөмж	69,769,581.15	80,793,441.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,188,007.03)	(24,064,007.97)
39207	Тавилга, эд хогшил	49,050,192.51	34,736,041.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,115,315.78)	(14,263,281.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,386,390.00	11,546,390.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(898,160.13)	(1,360,049.16)
39217	Ном	295,700.00	-
393	Биет бус хөрөнгийн дүн	116,966,000.00	116,702,000.00
39301	Программ хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хасагдуулга	(22,000.00)	(286,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	115,668,000.00	115,668,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,600,140,615.41	1,475,735,356.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,600,140,615.41	1,475,735,356.50
51	Засгийн газрын хувь оролцоо	115,668,000.00	115,668,000.00
511	Засгийн газрын оруулсан капитал	115,668,000.00	115,668,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,484,472,615.41	1,360,067,356.50
51210	Өмнөх үеийн үр дүн	1,484,472,615.41	1,484,472,615.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	(124,405,258.91)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	1,600,140,615.41	1,475,735,356.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	850,829,668.36	790,611,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,582,168.36	37,366,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,582,168.36	37,366,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,320,000.00	2,160,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,320,000.00	2,160,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	40,262,168.36	19,644,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	15,562,250.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	809,247,500.00	753,245,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	779,247,500.00	716,878,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	779,247,500.00	716,878,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,000,000.00	36,366,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,000,000.00	36,366,600.00
2	Үйл ажиллагааны зардал	781,306,264.71	915,016,508.91
21	Урсгал зардал	781,306,264.71	915,016,508.91
210	Бараа, үйлчилгээний зардал	780,297,284.82	909,313,948.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	540,930,903.95	643,508,313.51
210101	Үндсэн цалин	382,695,493.43	434,685,862.90
210102	Нэмэгдэл цалин	143,826,700.52	167,145,680.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт		23,251,500.00
210104	Урамшуулал	14,408,710.00	18,425,270.00
210105	Гэрээтийн цалин	-	
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	68,135,799.45	81,483,183.04
210201	Тэтгэврийн даатгалын	46,551,228.88	55,788,300.00
210202	тэтгэмжийн даатгалын	5,725,017.01	6,607,900.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,885,757.71	3,304,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,594,758.94	3,304,000.00
210205	ЭМ-ийн даатгалын	10,379,036.91	12,478,983.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,493,370.11	22,664,039.90
210301	Гэрэл цахилгааны зардал	6,175,228.11	8,333,872.83
210302	Түлш, халаалтын зардал	6,291,466.28	6,061,086.68
210303	Цэвэр бохир усны зардал	8,026,675.72	8,269,080.39
2104	Хангамж, бараа материалын зардал	9,164,300.00	7,481,944.35
210401	Бичиг хэргийн зардал	7,257,210.00	373,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,907,090.00	896,390.00
210406	Бараа материал акталсны зардал		6,212,054.35
2105	Нормативт зардал	77,287,726.59	79,092,772.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	938,350.00	188,800.00
210502	Хоол, хүнс	76,349,376.59	78,903,972.91
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,527,650.00	8,000,000.00
210604	Урсгал засварын зардал	8,527,650.00	8,000,000.00

2107	Томилолтын зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	2,245,000.00	2,002,900.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,245,000.00	2,002,900.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	53,512,534.72	65,080,795.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,476,950.12	8,417,880.12
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		5,724,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,035,584.60	50,938,814.98
213	Урсгал шилжүүлэг	1,008,979.89	5,702,560.10
	Бусад урсгал шилжүүлэг		
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,008,979.89	5,702,560.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,008,979.89	5,702,560.10
3	Үйл ажиллагааны үр дүн	69,523,403.65	(124,405,258.91)
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	69,523,403.65	(124,405,258.91)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	809,247,500.00	753,245,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	809,247,500.00	753,245,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	779,247,500.00	716,878,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	779,247,500.00	716,878,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,000,000.00	36,366,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,000,000.00	36,366,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	740,705,636.52	863,945,606.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	740,705,636.52	863,945,606.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,696,656.63	858,243,046.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	540,930,903.95	643,508,313.51
210101	Үндсэн цалин	382,695,493.43	434,685,862.90
210102	Нэмэгдэл	143,826,700.52	167,145,680.61
210103	Хоол унаа хөнгөлөлт		23,251,500.00
210104	Урамшуулал	14,408,710.00	18,425,270.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,135,799.45	81,483,183.04
210201	Тэтгэврийн даатгалын	46,551,228.88	55,788,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын	5,725,017.01	6,607,900.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,885,757.71	3,304,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,594,758.94	3,304,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	10,379,036.91	12,478,983.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,493,370.11	22,664,039.90
210301	Гэрэл цахилгааны зардал	6,175,228.11	8,419,698.19
210302	Түлш, халаалтын зардал	6,291,466.28	6,061,086.68
210303	Цэвэр бохир усны зардал	8,026,675.72	8,183,255.03
2104	Хангамж, бараа материал	-	-
210401	Бичиг хэргийн зардал		
2105	Нормативт зардал	77,318,923.00	78,624,500.00
210502	Хоол, хүнс	77,318,923.00	78,624,500.00
2106	Эд хогшил урсгал засвар	8,497,650.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,497,650.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,245,000.00	2,122,900.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,245,000.00	2,122,900.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,075,010.12	21,840,110.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,977,560.12	14,603,810.12
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,097,450.00	7,236,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,979.89	5,702,560.10
	Бусад урсгал шилжүүлэг		
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,008,979.89	5,702,560.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,008,979.89	5,702,560.10
22	Хөрөнгийн зардал		
2220	Дотоод эх үүсвэрээр	-	-
225108	Бусад хөрөнгө		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	68,541,863.48	(110,700,606.67)
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн		1,239,800.00
22	Хөрөнгийн зардал	-	1,239,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		1,239,800.00
223001	Бусад хөрөнгө	769,970.00	1,239,800.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	67,771,893.48	(111,940,406.67)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		165,663,541.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		53,723,135.32

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	115,668,000.00		1,484,472,615.41	1,530,617,211.76
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			69,523,403.65	69,523,403.65
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	115,668,000.00		1,484,472,615.41	1,600,140,615.41
НББ-ийн бодлогын өөрчлөлт			-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(124,405,258.91)	(124,405,258.91)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	115,668,000.00	-	1,360,067,356.50	1,475,735,356.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	908,342,700.00	859,482,846.57	48,859,853.43	94.6
21	Урсгал зардлын дүн	908,342,700.00	859,482,846.57	48,859,853.43	94.6
210	Бараа үйлчилгээний зардал	908,342,700.00	859,482,846.57	48,859,853.43	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,366,200.00	643,508,313.51	19,857,886.49	97.0
210101	Үндсэн цалин	456,017,000.00	434,685,862.90	21,331,137.10	95.3
210102	Нэмэгдэл	193,121,200.00	167,145,680.61	25,975,519.39	86.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт		23,251,500.00	(23,251,500.00)	
210104	Урамшуулал	14,228,000.00	18,425,270.00	(4,197,270.00)	129.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,541,700.00	81,483,183.04	1,058,516.96	98.7
210201	Тэтгэврийн даатгал	56,007,000.00	55,788,300.00	218,700.00	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	6,633,600.00	6,607,900.00	25,700.00	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,316,900.00	3,304,000.00	12,900.00	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,316,900.00	3,304,000.00	12,900.00	99.6
210205	ЭМД-ын хураамж	13,267,300.00	12,478,983.04	788,316.96	94.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,147,800.00	22,664,039.90	10,483,760.10	68.4
210301	Гэрэл цахилгааны зардал	10,456,000.00	8,419,698.19	2,036,301.81	80.5
210302	Түлш, халаалтын зардал	10,947,800.00	6,061,086.68	4,886,713.32	55.4
210303	Цэвэр бохир усны зардал	11,744,000.00	8,183,255.03	3,560,744.97	69.7
2105	Нормативт зардал	93,344,300.00	78,624,500.00	14,719,800.00	84.2
210502	Хоол хүнс	93,344,300.00	78,624,500.00	14,719,800.00	84.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	3,916,900.00	2,122,900.00	1,794,000.00	54.2
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,916,900.00	2,122,900.00	1,794,000.00	54.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,025,800.00	23,079,910.12	945,889.88	96.1

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,789,500.00	15,843,610.12	945,889.88	94.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,236,300.00	7,236,300.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	908,342,700.00	747,542,439.90	160,800,260.10	82.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	716,470,100.00	716,878,400.00	(408,300.00)	100.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	716,470,100.00	716,878,400.00	(408,300.00)	100.1
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,147,800.00	30,664,039.90	10,483,760.10	74.5
132001	Орон нутгийн төсвөөс	41,147,800.00	30,664,039.90	10,483,760.10	74.5
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	150,724,800.00	-	150,724,800.00	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		165,663,541.99		
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		53,723,135.32	53,723,135.32	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	27.00	(3.00)	90.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	17.00	14.00	(3.00)	82.4
	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,850.7 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 17 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгаагдаагүй хөрөнгийг бүртгэнэ.
- Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.04.24-ны өдрийн Б/10, 2025.05.26-ны өдрийн Б/13 тоот тушаалаар сантехникч Ц.Мөнх-Очирыг манаачаар хавсран ажил гүйцэтгүүлсэн байна. Хавсран гүйцэтгэсэн хугацааны цалинг тооцоолон бодохдоо МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.2-т зааснаар "түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэснийг зөрчиж үндсэн цалингаас тооцсон байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар суутгаж тооцож авна.

Аудитаар нийт 4,303.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,703.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус цэцэрлэгийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Б.Сарангэрэлд 600.0 төгрөг олгосон байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 7-д "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх) буюу Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1 Илрүүлэлт: Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Сарангэрэл нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна**", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2.2 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн нягтлан бодогч Ц.Лэгжмаад Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул 1,559.0 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус цэцэрлэгийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар 17 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлсэнийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгаадаагүй хөрөнгийг бүртгэнэ.	1	5,788.7	1	5,788.7	-	-	1	5,788.7	-	-	-	-
Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.04.24-ны өдрийн Б/10, 2025.05.26-ны өдрийн Б/13 тоот тушаалаар сантехникч Ц.Мөнх-Очирыг манаачаар хавсран ажил гүйцэтгүүлсэн байна. Хавсран гүйцэтгэсэн хугацааны цалинг тооцоолон бодоходоо МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.2-т зааснаар "түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэснийг зөрчиж үндсэн цалингаас тооцсон байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар суутгаж тооцож авна.	1	62.0			1	62.0	1	62.0				
Дүн	1	5,850.7	-	-	1	62.0	1	5,850.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Сарангэрэл нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс олгосон байна.	1	2,144.0	-	-	1	2,144.0	-	-	-	-	-	-
Тайлант онд нягтлан бодогчид балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	1	1,559.0			1	1,559.0						
Тайлант онд тус цэцэрлэгийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Б.Сарангэрэлд олгосон байна.	1	600.0	1	600.0								
Дүн	3	4,303.0	1	600.0	1	3,703.0	-	-	-	-	-	-